

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Эх, хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төвийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: САГ-2026/361/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: <a href="http://www.audit.mn">www.audit.mn</a> Улаанбаатар хот 2026 он	Санхүүгийн газрын захирал, тэргүүлэх аудитор: Ц.Наранчимэг Утас:261663 Цахим хаяг: <a href="mailto:naranchimegts@audit.gov.mn">naranchimegts@audit.gov.mn</a> Аудитын менежер: В.Эрдэнэцогт Утас:323266 Цахим хаяг: <a href="mailto:erdenetsogtv@audit.gov.mn">erdenetsogtv@audit.gov.mn</a> Ахлах аудитор: М.Пагамдулам Утас: 323266 Цахим хаяг: <a href="mailto:pagamdulamm@audit.gov.mn">pagmadulamm@audit.gov.mn</a> Гэрэлт хөхийн тэнцвэр аудит ХХК-ийн захирал: Д.Баатарсайхан Утас: 99099119 Цахим хаяг: <a href="mailto:gerelthuhaudit@gmail.com">gerelthuhaudit@gmail.com</a>
--	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## АГУУЛГА

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ .....	2
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ .....	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан .....	5
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан .....	6
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан .....	7
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан .....	9
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан .....	9
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА .....	11
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа .....	11
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин .....	12
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал .....	12
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд .....	13
3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв .....	14
4. АУДИТЫН ТАЙЛАН .....	16
4.1 Ерөнхий зүйл .....	16
4.2 Материаллаг байдал .....	17
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт .....	17
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал .....	17
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт .....	17
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт .....	18
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал .....	19
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ .....	19
5.1 Төлбөрийн акт .....	20
5.2 Албан шаардлага .....	20
5.3 Зөвлөмж .....	22
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ .....	24

### Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл
ЭХЭМҮТ	Эх, хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төв
ЭМДС	Эрүүл мэндийн даатгалын сан
ЭМЯ	Эрүүл мэндийн яам



## ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

Засгийн газрын IV байр, Бага тойруу 3,  
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160  
Утас: 26 04 37, Факс: (976-51) 26 42 30,  
Цахим шуудан: info@audit.gov.mn,  
Цахим хуудас: www.audit.mn

2026.03.10 № 06/575  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

### Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Эх, хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төвийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл хэсэгт тайлбарласан зүйлсийн үр нөлөөг эс тооцвол 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу бүхий л материаллаг байдлын үүднээс үнэн зөв толилуулсан байна.

### Хязгаарлалттай санал дүгнэлтийн дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторовын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бусаар гүйцэтгэж, аудиторовын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайлангийн аудитаар нийт 2,932,836.9 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрсэн нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс давсан бөгөөд дангаараа болон нийт дүнгээрээ санхүүгийн тайланд материаллаг нөлөөтэй боловч өргөн тархаагүй байна. Тухайлбал:

- Эрүүл мэндийн сайдын 2025 оны А/05 дугаар тушаалаар 1,281,028.7 мянган төгрөгийн хүчилтөрөгчийн үйлдвэр болон тоног төхөөрөмжийг орлогод авсан боловч ашиглалтад оруулаагүй, хөрөнгийн ашиглалтыг сайжруулах талаар арга хэмжээ аваагүй;
- Нэгдсэн үндэсний хүүхдийн сангаас санхүүжүүлсэн Хүүхдийн дүрс оношилгооны чадавхыг бэхжүүлэх сургалт, Хүүхдийн зүрхний олдмол гажгийг оношлох эмч бэлтгэх, зүрхний хэт авайн оношилгооны чадамж олгох сургалт, Сургуульд суурилсан эрт илрүүлэг, үзлэгийн зүрхний эмгэгийг орон нутагт илрүүлэх багийн ажиллагаа үзлэг сургалтуудад, нийт 226,832.4 мянган төгрөгийн урьдчилгаа олгоод тооцоог хийж, зарцуулалтыг тайлагнаагүй;

Дээрх зөрчлүүд нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.5, 6.4.8, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4, 13 дугаар зүйлийн 13.7, 20 дугаар зүйлийн 20.2.5, 20.2.6 дахь заалтуудтай тус тус нийцээгүй.

### **Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг**

Эх хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төвийн амбулаторийн барилга шинээр ашиглалтад орсноор эх, хүүхдэд үзүүлэх эмчилгээний төрөл, хүртээмж өргөжсөн бөгөөд Эрүүл мэндийн сайдын 2025 оны 421 дүгээр тушаалыг үндэслэн Эх, хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төвийн захирлын 2025 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн 171 дүгээр тушаалаар Хүүхдийн мэдрэлийн мэс заслын тасгийг шинээр байгуулж, 19 хүүхдэд хагалгаа хийсэн нь амжилттай болсон байна.

### **Аудитын гол асуудал**

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Монгол улсад эмчлэгдэх боломжгүй өндөр өртөгтэй элэг шилжүүлэн суулгах мэс засал, бөөр шилжүүлэн суулгах мэс заслыг Нэгдүгээр эмнэлгийн нарийн мэргэжлийн эмч нарын багтай хамтран Монгол улсад анх удаа 6 хүүхдэд амжилттай хийж, эм, лабораторийн шинжилгээний зардалд 397,272.3 мянган төгрөг зарцуулсан байна.

### **Бусад асуудал**

Эх хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төвийн захирлын 2025 оны А/01 дүгээр тушаалаар эмч, эмнэлгийн ажилчдын цалинг 6 хувь буюу 9,222,075.6 мянган төгрөгөөр нэмэгдүүлсэн боловч цалингийн санг нэмж тодотгоогүйгээс жилийн эцэст 8,079,360.4 мянган төгрөгийн цалин, татвар, шимтгэлийн өртэй байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

### **Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН  
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>9,148,856,298.75</b>	<b>15,488,576,024.18</b>
<b>31</b>	<b>МӨНГӨН ХӨРӨНГӨ</b>	3,110,881,898.97	1,267,980,006.50
<b>312</b>	<b>Банканд байгаа бэлэн мөнгө</b>	3,110,881,898.97	1,267,980,006.50
<b>3121</b>	<b>Төгрөг</b>	3,110,881,898.97	1,267,980,006.50
31211	Төрийн сангийн харилцах	3,110,868,253.82	1,267,977,761.35
31213	Арилжааны банк дахь харилцах	13,645.15	2,245.15
<b>33</b>	<b>АВЛАГА</b>	2,049,121,712.00	7,588,033,518.15
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	21,678,407.68	4,781,303.50
33200	Төлбөртэй үйлчилгээний авлага	-	2,043,690.00
33300	Татаас, санхүүжилтийн авлага	1,660,363,355.65	7,461,482,797.65
<b>335</b>	<b>Бусад авлага</b>	367,079,948.67	119,725,727.00
3351	Байгууллагаас авах авлага	367,079,948.67	119,725,727.00
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	3,988,852,687.74	6,632,562,499.53
<b>351</b>	<b>Түүхий эд материал</b>	1,111,588,619.13	3,136,708,048.96
35130	Эм боох материал	1,111,588,619.13	3,136,708,048.96
<b>354</b>	<b>Хангамжийн материал</b>	2,877,264,068.61	3,495,854,450.57
35410	Бичиг хэргийн материал	7,923,165.00	4,719,244.00
35420	Аж ахуйн материал	62,558,011.80	63,643,248.39
35430	Сэлбэг хэрэгсэл	11,368,075.00	338,843,022.97
35440	Түлш, шатах тослох материал	3,540,000.00	4,391,364.00
35450	Барилгын засварын материал	-	8,108,866.00
35460	Хүнсний материал	15,699,659.00	87,058,153.65
35470	Бусад хангамжийн материал	2,776,175,157.81	2,989,090,551.56
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>71,764,133,331.31</b>	<b>107,202,916,262.25</b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	71,764,133,331.31	107,202,916,262.25
<b>392</b>	<b>Биет хөрөнгө</b>	65,546,092,538.34	100,968,896,580.44
39201	Барилга, байгууламж, орон сууц	59,185,400,672.66	73,081,532,500.66
39202	Хуримтлагдсан элэгдэл	(9,320,805,439.13)	(11,757,473,925.81)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	1,229,739,112.80	1,229,739,112.80
39204	Хуримтлагдсан элэгдэл	(511,552,507.94)	(616,303,705.58)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	55,975,649,001.21	82,738,889,970.84
39206	Хуримтлагдсан элэгдэл	(42,754,340,157.47)	(45,263,764,699.53)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	2,662,825,059.73	2,860,427,979.29
39208	Хуримтлагдсан элэгдэл	(1,797,540,071.94)	(1,969,932,514.01)
39209	Зам, гүүрийн байгууламж	1,651,926,779.50	1,651,926,779.50
39210	Хуримтлагдсан элэгдэл	(796,014,461.08)	(1,006,949,467.72)
39214	Бусад үндсэн хөрөнгө	566,713,294.62	566,713,294.62
39215	Хуримтлагдсан элэгдэл	(566,713,294.62)	(566,713,294.62)
39216	Дуусаагүй барилга, байгууламж	20,804,550.00	20,804,550.00
<b>393</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	6,218,040,792.97	6,234,019,681.81
39301	Программ хангамж	301,753,849.48	321,253,849.48
39302	Хуримтлагдсан элэгдэл	(288,401,556.51)	(291,922,667.67)
39303	Бусад биет бус хөрөнгө	6,204,688,500.00	6,204,688,500.00
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b>80,912,989,630.06</b>	<b>122,691,492,286.43</b>
<b>4</b>	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	<b>10,201,065,444.85</b>	<b>18,152,795,055.50</b>
<b>41</b>	<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	10,201,065,444.85	18,152,795,055.50
<b>413</b>	<b>Өглөг</b>	10,101,065,444.85	18,152,795,055.50
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	769,543,607.29	8,079,360,377.94
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	9,206,198,037.56	9,337,677,567.56
41340	Хөрөнгө бэлтгэхтэй холбогдсон өглөг	-	503,607,537.00
<b>4136</b>	<b>Бусад өглөг</b>	125,323,800.00	232,149,573.00
41361	Байгууллагад төлөх өглөг	125,323,800.00	232,149,573.00
<b>414</b>	<b>Урьдчилж орсон орлого</b>	100,000,000.00	-
41440	Бусад урьдчилж орсон орлого	100,000,000.00	-
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>70,711,924,185.21</b>	<b>104,538,697,230.93</b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	70,711,924,185.21	104,538,697,230.93

Эх хүүхдийн эрүүл мэндийн үдэсний төвийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	19,625,186,499.80	19,625,186,499.80
51101	Өмч: - төрийн	19,625,186,499.80	19,625,186,499.80
<b>512</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	<b>21,448,614,649.53</b>	<b>55,275,387,695.25</b>
51210	Өмнөх үеийн үр дүн	21,448,614,649.53	21,435,672,270.96
51220	Тайлант үеийн үр дүн		33,839,715,424.29
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	29,638,123,035.88	29,638,123,035.88
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b>80,912,989,630.06</b>	<b>122,691,492,286.43</b>

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>69,575,628,152.36</b>	<b>105,882,489,653.86</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>21,266,011,712.87</b>	<b>47,915,334,374.86</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	2,900,181,165.27	47,915,334,374.86
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	2,900,181,165.27	47,915,334,374.86
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,194,968,867.10	1,322,411,927.66
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,362,161,824.88	5,262,799,768.16
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	343,050,473.29	41,330,122,679.04
<b>122</b>	<b>Тусламжийн орлого</b>	18,365,830,547.60	-
122001	Хандив тусламж /дотоод/	18,365,830,547.60	-
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>48,309,616,439.49</b>	<b>57,967,155,279.00</b>
<b>1340</b>	<b>Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих</b>	48,309,616,439.49	57,967,155,279.00
134001	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	48,309,616,439.49	-
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	-	57,967,155,279.00
<b>2</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>69,984,881,418.33</b>	<b>72,042,723,049.57</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>69,984,862,312.23</b>	<b>72,042,723,049.57</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	68,982,773,097.90	70,798,249,487.34
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	34,983,817,803.94	38,483,015,443.19
210101	Үндсэн цалин	19,474,364,320.11	20,495,284,333.42
210102	Нэмэгдэл	11,830,966,163.83	14,303,303,730.43
210103	Унаа хоолны хөнгөлөлт	1,100,800,000.00	1,126,484,000.00
210104	Урамшуулал	2,577,687,320.00	2,557,943,379.34
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	4,382,501,079.00	4,758,305,354.08
210201	Тэтгэврийн даатгал	2,939,514,330.00	3,183,564,205.70
210202	Тэтгэмжийн даатгал	460,829,070.00	380,524,756.98
210203	ҮОМШӨ-ний даатгал	217,879,812.00	286,697,966.04
210204	Ажилгүйдлийн даатгал	152,278,881.00	165,242,258.95
210205	Эрүүл мэндийн даатгал	611,998,986.00	742,276,166.41
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	1,986,585,488.56	2,113,112,698.27
210301	Гэрэл, цахилгаан	830,058,212.31	1,090,161,901.56
210302	Түлш, халаалт	484,386,790.24	444,792,739.99
210303	Цэвэр, бохир ус	672,140,486.01	578,158,056.72
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	785,132,614.96	1,301,011,911.83
210401	Бичиг хэрэг	107,053,947.02	210,789,758.00
210402	Тээвэр, шатахуун	54,210,817.89	61,035,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	25,539,632.03	34,935,793.60
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	555,078,984.09	86,126,480.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	43,249,233.93	35,225,970.60
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал	-	458,225,742.01
210408	Бараа материал акталсны зардал	-	414,673,167.62
<b>2105</b>	<b>Норматив зардал</b>	18,106,902,459.93	17,016,836,527.02
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	16,088,687,662.23	15,807,760,169.27
210502	Хоол, хүнс	1,610,791,480.12	1,209,076,357.75

Эх хүүхдийн эрүүл мэндийн үдэсний төвийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	407,423,317.58	-
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>317,188,803.75</b>	<b>415,875,752.03</b>
210601	Багаж, техник, хэрэгсэл	29,819,971.45	-
210602	Тавилга	287,368,832.30	-
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	-	5,490,000.00
210604	Урсгал засвар	-	410,385,752.03
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>310,225,411.44</b>	<b>357,689,565.00</b>
210701	Гадаад албан томилолт	133,639,800.00	124,202,044.00
210702	Дотоод албан томилолт	176,585,611.44	233,487,521.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>189,565,758.04</b>	<b>211,605,390.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	133,350,540.00	92,457,049.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	16,500,000.00	16,500,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	-	1,100,628.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	3,438,049.96	-
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	308,000.00	-
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	-	85,400,000.00
210807	Газрын төлбөр	16,325,417.00	16,136,313.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	40,465.00	11,400.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	19,603,286.08	-
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>7,920,853,678.28</b>	<b>6,140,796,845.92</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	160,996,489.69	615,266,658.14
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	819,000.00	34,848,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	7,759,038,188.59	5,490,682,187.78
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>1,002,089,214.33</b>	<b>1,244,473,562.23</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>1,002,089,214.33</b>	<b>1,244,473,562.23</b>
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	938,865,629.33	1,194,263,189.03
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	63,223,585.00	50,210,373.20
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>19,106.10</b>	<b>-</b>
<b>2200</b>	<b>Дотоод эх үүсвэрээр</b>	<b>19,106.10</b>	<b>-</b>
221001	Их засвар	19,106.10	-
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>	<b>(409,253,265.97)</b>	<b>33,839,766,604.29</b>
<b>225</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>-</b>	<b>51,180.00</b>
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	-	51,180.00
<b>4</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)</b>	<b>-</b>	<b>(51,180.00)</b>
<b>5</b>	<b>НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)</b>	<b>(409,253,265.97)</b>	<b>33,839,715,424.29</b>

### 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b>59,724,507,355.93</b>	<b>58,718,122,432.62</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>7,270,184,875.58</b>	<b>6,552,086,595.62</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	<b>7,270,184,875.58</b>	<b>6,552,086,595.62</b>
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	7,270,184,875.58	6,552,086,595.62
1E+06	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,232,014,801.10	1,334,711,210.96
1E+06	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	6,038,170,074.48	5,217,375,384.66
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>52,454,322,480.35</b>	<b>52,166,035,837.00</b>
<b>1340</b>	<b>Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих</b>	<b>52,454,322,480.35</b>	<b>52,166,035,837.00</b>
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	52,454,322,480.35	52,166,035,837.00
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	<b>56,736,719,459.18</b>	<b>59,153,701,124.09</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>56,736,719,459.18</b>	<b>59,153,701,124.09</b>

Эх хүүхдийн эрүүл мэндийн үдэсний төвийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>55,728,010,244.85</b>	<b>57,904,803,641.86</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>35,868,837,926.79</b>	<b>32,353,149,464.57</b>
210101	Үндсэн цалин	17,990,383,685.91	14,887,186,367.20
210102	Нэмэгдэл	14,374,475,006.58	13,809,740,811.24
210103	Унаа хоолны хөнгөлөлт	1,096,165,396.63	1,120,249,351.71
210104	Урамшуулал	2,407,813,837.67	2,535,972,934.42
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>4,986,946,118.87</b>	<b>3,571,377,413.26</b>
210201	Тэтгэврийн даатгал	3,769,063,329.18	2,250,896,571.48
210202	Тэтгэмжийн даатгал	399,357,950.13	292,949,502.58
210203	ҮОМШӨ-ний даатгал	169,637,469.64	103,111,470.78
210204	Ажилгүйдлийн даатгал	171,003,557.99	73,835,631.59
210205	Эрүүл мэндийн даатгал	477,883,811.93	850,584,236.83
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>1,977,563,206.28</b>	<b>2,060,593,167.95</b>
210301	Гэрэл, цахилгаан	841,999,619.31	1,090,161,901.56
210302	Түлш, халаалт	536,577,222.56	392,273,209.67
210303	Цэвэр, бохир ус	598,986,364.41	578,158,056.72
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>589,619,555.03</b>	<b>1,012,373,659.80</b>
210401	Бичиг хэрэг	53,390,992.00	119,799,212.00
210402	Тээвэр, шатахуун	45,000,000.00	59,190,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	28,390,732.03	33,677,793.60
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	343,848,427.00	619,980,327.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	118,989,404.00	179,726,327.20
<b>2105</b>	<b>Норматив зардал</b>	<b>10,957,301,070.21</b>	<b>16,891,204,220.55</b>
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	9,961,998,641.21	14,735,948,128.15
210502	Хоол, хүнс	948,703,929.00	1,755,049,542.40
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	46,598,500.00	400,206,550.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>669,346,448.17</b>	<b>451,622,250.00</b>
210601	Багаж, техник, хэрэгсэл	444,616,979.17	63,108,000.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	21,621,000.00	6,546,000.00
210604	Урсгал засвар	203,108,469.00	381,968,250.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>310,544,238.00</b>	<b>357,689,565.00</b>
210701	Гадаад албан томилолт	144,453,600.00	124,202,044.00
210702	Дотоод албан томилолт	166,090,638.00	233,487,521.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>193,641,872.00</b>	<b>232,547,028.80</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	151,498,610.00	92,457,049.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	16,500,000.00	16,500,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	2,206,150.00	1,100,628.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	1,147,430.00	
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	308,000.00	
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ		50,000,000.00
210807	Газрын төлбөр	16,325,417.00	16,136,313.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	47,265.00	5,728,138.80
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	5,609,000.00	50,624,900.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>174,209,809.50</b>	<b>974,246,871.93</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	171,753,809.50	939,398,871.93
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,456,000.00	34,848,000.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>1,008,709,214.33</b>	<b>1,248,897,482.23</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>1,008,709,214.33</b>	<b>1,248,897,482.23</b>
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	938,865,629.33	1,194,263,189.03
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	69,843,585.00	54,634,293.20
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)</b>	<b>2,987,787,896.75</b>	<b>(435,578,691.47)</b>
<b>5</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)</b>	<b>492,498,892.83</b>	<b>1,407,323,201.00</b>
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>492,498,892.83</b>	<b>1,407,323,201.00</b>
<b>2200</b>	<b>Дотоод эх үүсвэрээр</b>	<b>492,498,892.83</b>	<b>1,407,323,201.00</b>

Эх хүүхдийн эрүүл мэндийн үдэсний төвийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	492,498,892.83	1,407,323,201.00
<b>6</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)</b>	<b>(492,498,892.83)</b>	<b>(1,407,323,201.00)</b>
<b>8</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)</b>	2,495,289,003.92	(1,842,901,892.47)
<b>9</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	515,592,896.23	3,110,881,898.97
<b>10</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	3,010,881,900.15	1,267,980,006.50

#### 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан үр дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
1	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	19,625,186,499.80	29,638,123,035.88	21,857,867,915.50	71,121,177,451.18
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	19,625,186,499.80	29,638,123,035.88	21,857,867,915.50	71,121,177,451.18
9	Тайлант үеийн үр дүн	-	-	(409,253,265.97)	(409,253,265.97)
10	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	19,625,186,499.80	29,638,123,035.88	21,448,614,649.53	70,711,924,185.21
11	2025 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	19,625,186,499.80	29,638,123,035.88	21,448,614,649.53	70,711,924,185.21
12	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	(12,942,378.57)	(12,942,378.57)
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	19,625,186,499.80	29,638,123,035.88	21,435,672,270.96	70,698,981,806.64
19	Тайлант үеийн үр дүн	-	-	33,839,715,424.29	33,839,715,424.29
20	2025 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	19,625,186,499.80	29,638,123,035.88	55,275,387,695.25	104,538,697,230.93

#### 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
<b>1</b>	<b>НИЙТ ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН</b>	<b>59,899,563,900.00</b>	<b>58,713,998,432.62</b>	<b>1,185,565,467.38</b>	<b>98.0</b>
12	Татварын бус орлого	59,899,563,900.00	58,713,998,432.62	1,185,565,467.38	98.0
120	Нийтлэг татварын бус орлого	7,731,518,900.00	6,547,962,595.62	1,183,556,304.38	84.7
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого /үндсэн/	1,950,604,000.00	1,330,587,210.96	620,016,789.04	68.2
120010	Төсөв байгууллагын өөрийн орлого /туслах/	5,780,914,900.00	5,217,375,384.66	563,539,515.34	90.3
122	Тусламжийн орлого	52,168,045,000.00	52,166,035,837.00	2,009,163.00	100.0
122001	Хандив тусламж /дотоод/	52,168,045,000.00	52,166,035,837.00	2,009,163.00	100.0
<b>II</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>62,754,327,800.00</b>	<b>60,555,296,186.29</b>	<b>2,199,031,613.71</b>	<b>96.5</b>

Эх хүүхдийн эрүүл мэндийн үдэсний төвийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>62,754,327,800.00</b>	<b>60,555,296,186.29</b>	<b>2,199,031,613.71</b>	<b>96.5</b>
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	61,074,460,000.00	59,306,398,704.06	1,768,061,295.94	97.1
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	32,471,043,900.00	32,353,149,464.57	117,894,435.43	99.6
210101	Үндсэн цалин	19,485,787,100.00	14,887,186,367.20	4,598,600,732.80	76.4
210102	Нэмэгдэл	5,713,756,400.00	13,809,740,811.24	(8,095,984,411.24)	241.7
210103	Унаа хоолны хөнгөлөлт	4,742,282,900.00	1,120,249,351.71	3,622,033,548.29	23.6
210104	Урамшуулал	2,529,217,500.00	2,535,972,934.42	(6,755,434.42)	100.3
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	3,578,648,800.00	3,571,377,413.26	7,271,386.74	99.8
210201	Тэтгэврийн даатгал	1,572,387,200.00	2,250,896,571.48	(678,509,371.48)	143.2
210202	Тэтгэмжийн даатгал	659,383,700.00	292,949,502.58	366,434,197.42	44.4
210203	ҮОМШӨ-ний даатгал	171,873,400.00	103,111,470.78	68,761,929.22	60.0
210204	Ажилгүйдлийн даатгал	171,873,400.00	73,835,631.59	98,037,768.41	43.0
210205	Эрүүл мэндийн даатгал	1,003,131,100.00	850,584,236.83	152,546,863.17	84.8
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	2,088,503,300.00	2,060,593,167.95	27,910,132.05	98.7
210301	Гэрэл, цахилгаан	1,005,344,600.00	1,090,161,901.56	(84,817,301.56)	108.4
210302	Түлш, халаалт	518,158,700.00	392,273,209.67	125,885,490.33	75.7
210303	Цэвэр, бохир ус	565,000,000.00	578,158,056.72	(13,158,056.72)	102.3
2104	Хангамж, бараа материалын зардал	1,061,141,400.00	1,036,990,999.80	24,150,400.20	97.7
210401	Бичиг хэрэг	119,526,100.00	119,799,212.00	(273,112.00)	100.2
210402	Тээвэр, шатахуун	45,000,000.00	59,190,000.00	(14,190,000.00)	131.5
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	27,814,000.00	33,677,793.60	(5,863,793.60)	121.1
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	701,324,000.00	619,980,327.00	81,343,673.00	88.4
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	167,477,300.00	204,343,667.20	(36,866,367.20)	122.0
2105	Нормативт зардал	18,341,154,700.00	16,891,204,220.55	1,449,950,479.45	92.1
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	15,831,826,000.00	14,735,948,128.15	1,095,877,871.85	93.1
210502	Хоол, хүнс	2,154,378,900.00	1,755,049,542.40	399,329,357.60	81.5
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	354,949,800.00	400,206,550.00	(45,256,750.00)	112.8
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,154,550,900.00	1,291,308,031.00	(136,757,131.00)	111.8
210601	Багаж, техник, хэрэгсэл	335,357,100.00	532,993,490.00	(197,636,390.00)	158.9
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	10,000,000.00	6,546,000.00	3,454,000.00	65.5
210604	Урсгал засвар	809,193,800.00	751,768,541.00	57,425,259.00	92.9
2107	Томилолт, зочны зардал	406,797,600.00	357,689,565.00	49,108,035.00	87.9
210701	Гадаад албан томилолт	124,304,400.00	124,202,044.00	102,356.00	99.9
210702	Дотоод албан томилолт	282,493,200.00	233,487,521.00	49,005,679.00	82.7
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	301,536,100.00	246,318,890.00	55,217,210.00	81.7
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	161,924,700.00	111,957,049.00	49,967,651.00	69.1
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	16,500,000.00	16,500,000.00	-	100.0
210803	Даатгалын үйлчилгээ	3,500,000.00	1,100,628.00	2,399,372.00	31.4
210804	Тээврийн хэрэгслийн татвар	1,733,600.00	-	1,733,600.00	-
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	500,000.00	-	500,000.00	-
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	50,000,000.00	50,000,000.00	-	100.0
210807	Газрын төлбөр	16,636,300.00	16,136,313.00	499,987.00	97.0
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	50,741,500.00	50,624,900.00	116,600.00	99.8
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	1,671,083,300.00	1,497,766,951.93	173,316,348.07	89.6

Эх хүүхдийн эрүүл мэндийн үдэсний төвийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

210901	Бараа үйлчилгээний бусад зардал	1,613,399,600.00	1,462,918,951.93	150,480,648.07	90.7
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	57,683,700.00	34,848,000.00	22,835,700.00	60.4
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,679,867,800.00	1,248,897,482.23	430,970,317.77	74.3
2132	Бусад урсгал шилжүүлэг	1,679,867,800.00	1,248,897,482.23	430,970,317.77	74.3
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	1,625,169,100.00	1,194,263,189.03	430,905,910.97	73.5
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	54,698,700.00	54,634,293.20	64,406.80	99.9
<b>8</b>	<b>ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН НИЙТ ТЭНЦЭЛ</b>	<b>(2,854,763,900.00)</b>	<b>(1,841,297,753.67)</b>	<b>(1,013,466,146.33)</b>	<b>64.5</b>
<b>9</b>	<b>АЛДАГДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>2,854,763,900.00</b>	<b>1,841,297,753.67</b>	<b>1,013,466,146.33</b>	<b>64.5</b>
7	Харилцах болон хадгаламжийн дансны цэвэр өөрчлөлт	2,854,763,900.00	1,841,297,753.67	1,013,466,146.33	64.5
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	3,110,868,253.82	(3,110,868,253.82)	
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	1,267,977,761.35	(1,267,977,761.35)	
6	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ	2,013.00	2,013.00	-	100.0
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1.00	1.00	-	100.0
610001	Төсвийн байгууллага	1.00	1.00	-	100.0
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	1,006.00	1,006.00	-	100.0
620001	Удирдах ажилтан	1.00	1.00	-	100.0
620002	Гүйцэтгэх ажилтан	774.00	774.00	-	100.0
620003	Үйлчлэх ажилтан	231.00	231.00	-	100.0
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	1,006.00	1,006.00	-	100.0
650008	Эрүүл мэндийн салбарын төрийн үйлчилгээний албан хаагч (ТҮЭМ)	775.00	775.00	-	100.0
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	231.00	231.00	-	100.0

### 3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

#### 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Эх, хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төв нь эрхэм зорилгоо “Монгол улсад эх, хүүхдэд эмнэлгийн төрөлжсөн мэргэжлийн тусламжийг чанарын өндөр түвшинд, үйлчлүүлэгчээ дээдэлсэн тав тухтай орчинд үзүүлж, дэлхийн жишигт хүрсэн үйлчилгээг эрхэмлэнэ” гэж тодорхойлсон байна.

Дээрх зорилтын хүрээнд үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Улсын хэмжээнд эх, хүүхдэд нотолгоонд тулгуурласан эрүүл мэндийн төрөлжсөн мэргэжлийн гурав дахь шатлалын тусламж үйлчилгээ үзүүлэх;
- Эх барих эмэгтэйчүүд, хүүхдийн дотор, мэс заслын чиглэлээр төгсөлтийн дараах сургалт эрхлэн явуулах, салбарын тэргүүлэх эмч мэргэжилтэн бэлтгэх;
- Эх хүүхдийн талаар баримтлах төрийн бодлогыг хэрэгжүүлж, эрүүл мэндийн тусламж үйлчилгээг боловсронгуй болгох, эрүүл мэндийн байгууллагуудад мэргэжил арга зүйн лавлагаа тусламж үзүүлэх;
- Гүйцэтгэлд суурилсан санхүүжилтийн системийг нэвтрүүлэх;

Тайлант оны онцлох үйл явдал:

- “Хүүхдийн зүрх төсөл”-ийг тус эмнэлэг нь АНУ, Канад, БНСУ, Япон улсын эмнэлгийн эмч нартай хамтран хэрэгжүүлж зүрхний төрөлхийн гажигтай 300 хүүхдэд мэс засал, 200 гаруй хүүхдэд эмчилгээ, оношилгооны зүрх сэтгүүрдэх ажилбар хийгдсэн байна.
- БНХАУ-ын Фудан их сургуулийн хүүхдийн эмнэлэгт “Хүүхэд нярайн зүрхний мэс засал”-ын сургалтад 8 эмч мэргэжилтэн, 1-6 сарын хугацаатай сургалтад хамруулсан байна.

### 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Эх, хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төв нь Эрүүл мэндийн тухай хууль, Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний тухай хууль, Эрүүл мэндийн даатгалын тухай хууль, Төсвийн тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон бусад хууль тогтоомжид нийцүүлэн үндсэн чиг үүргээ хэрэгжүүлж байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт орсон байна. Тухайлбал:

- Төсвийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт;
- Сангийн сайдын 2025 оны А/03 дугаар тушаалаар баталсан “Төсвийн байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам”;
- Сангийн сайдын 2025 оны А/112 дугаар тушаалаар баталсан “Төсвийн зарлагын эдийн засгийн ангилал, тайлбар, зардлын зориулалт болон арга хэмжээний ангилал”;
- Сангийн сайдын 2025 оны 240 дүгээр тушаалаар баталсан “Төсвийн зарлагын хэмнэлт, үндсэн үйл ажиллагааны нэмэлт орлогыг зарцуулах, тайлагнах, нягтлан бодох бүртгэлд тусгах, хяналт тавих журам”;
- ЭМДҮЗ-ийн 2025 оны 1 дүгээр сарын 23-ны өдрийн 4 дүгээр тогтоолоор “Жагсаалт, төлбөрийн хэмжээ, төлбөрийн арга, журам”-ыг тус тус шинэчлэн баталсан байна.

Эх, хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төвийн удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөгүй байна.

Дотоод аудиторын батлагдсан орон тоо байхгүй тул тайлант онд дотоод аудит хийгдээгүй байна.

Дотоод аудиторын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах шаардлагагүй гэж үзлээ.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Эх, хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төвийн 2025 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Эх хүүхдийн эрүүл мэндийн төвийн захирлын 2020 оны 05 дугаар сарын 28-ны А/54 дугаар тушаалаар байгууллагын мөрдөж буй нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийн батлан мөрдөж байна.

Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцээгүй, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохироогүй, байгууллагын үйл ажиллагаанд мөрдөгддөг хууль, журам, тогтоол шийдвэрүүдийн нэмэлт өөрчлөлтөд нийцүүлэн батлаагүй байна.

### 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Эх, хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төвийн 2025 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2025 оны А/03 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 41,778,502.7 мянган төгрөгөөр буюу 51.6 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	3,110,881.9	1,267,980.0	(1,842,901.9)
Авлага	2,049,121.7	7,588,033.5	5,538,911.8
Бараа материал	3,988,852.7	6,632,562.5	2,643,709.8
Үндсэн хөрөнгө	71,764,133.3	107,202,916.3	35,438,783.0
<b>Нийт хөрөнгө</b>	<b>80,912,989.6</b>	<b>122,691,492.3</b>	<b>41,778,502.7</b>
Өр төлбөр	10,201,065.4	18,152,795.1	7,951,729.7
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	70,711,924.2	104,538,697.2	33,826,773.0
<b>Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн</b>	<b>80,912,989.6</b>	<b>122,691,492.3</b>	<b>41,778,502.7</b>

Эх сурвалж нь: ЭХЭМҮТөвийн 2025 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан

Дээрх хүснэгтээс харахад өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан нь мөнгөн хөрөнгө, авлага, бараа материал, үндсэн хөрөнгө, өр төлбөр, засгийн газрын оролцооны данснууд байна. Үүнд:

Мөнгөн хөрөнгийн дансны үлдэгдэл 1,267,980.0 мянган төгрөг болж өмнө оноос 1,842,901.9 мянган төгрөгөөр буурсан нь ЭМДС-аас 52,166,035.8 мянган төгрөг, үндсэн үйл ажиллагааны орлогоос 1,334,711.2 мянган төгрөг, туслах үйл ажиллагааны орлогоос 5,217,375.4 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, үйл ажиллагаанд 58,185,135.5 мянган, биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал 1,407,323.1 мянган төгрөг зарцуулсантай холбоотой байна.

Авлага дансны үлдэгдэл 7,588,033.5 мянган төгрөг болж өмнөх оноос 5,538.911.8 мянган төгрөгөөр өссөн нь ЭМДС-аас авах санхүүжилтийн авлага 5,801,119.4 мянга, ажиллагчдаас авах авлага 653.1 мянган төгрөг, төлбөртэй үйлчилгээний авлага 2,043.0 мянга, байрны түрээсийн авлага 43,530.7 мянган төгрөгөөр тус тус нэмэгдэж, бусад зардлын тооцооны авлага 290,884.9 мянган төгрөгөөр буурсан нь голлон нөлөөлсөн байна.

Бараа материал дансны үлдэгдэл 6,632,562.5 мянган төгрөг болж өмнөх оноос 2,643,709.8 мянган төгрөгөөр өссөн нь төсвийн хөрөнгөөр худалдан авсан 18,261,250.4 мянган төгрөг, үнэ төлбөргүй хүлээн авсан 2,657,837.4 мянган төгрөгөөр тус тус нэмэгдэж, эмнэлгийн үйл ажиллагаанд 17,801,971.8 мянган төгрөгийн бараа материал, эм, эмнэлгийн хэрэгслийг зарцуулж, 464,406.2 мянган төгрөгийн бараа материалыг акталж устгасан нь голлон нөлөөлжээ.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 107,202,916.3 мянган төгрөг болж өмнөх оноос 35,438,783.0 мянган төгрөгөөр өссөн нь ЭМЯ, НҮБ, ХӨСҮТ, Дэлхийн эрүүл мэндийн байгууллага, Оюу толгой ХХК, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам болон бусад байгууллагуудаас хандив, тусламжаар 38,659,485.3 мянган төгрөгийн хөрөнгийг тус тус хүлээн авч, төсвийн хөрөнгөөр 2,270,031.0 мянган төгрөгийн хөрөнгө худалдан авч, данс бүртгэлээс 5,304.0 мянган төгрөгийн хөрөнгийг акталсан нь голлон нөлөөлсөн байна.

Нийт өр төлбөрийн данс 18,152,795.1 мянган төгрөг болж 7,951,729.7 мянган төгрөгөөр өссөн нь ажилчидтай холбоотой өр төлбөр 7,263,259.6 мянган төгрөг, эм эмнэлгийн хэрэгслийн худалдан авалтын өглөг 482,737.6 мянган төгрөг, бусад зардлын өглөг 104,185.8 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь голлон нөлөөлсөн байна.

Засгийн газрын хувь оролцоо дансны үлдэгдэл 104,538,697.23 мянган төгрөг болж өмнөх оноос 33,826.8 мянган төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүнгээс шалтгаалжээ.

#### Программ хангамжийн талаарх судалгааны үр дүн:

Байгууллагын үйл ажиллагаанд нийт 321,253.8 мянган төгрөгийн 12 программ хангамжийг ашигладаг бөгөөд тайлант онд систем хөгжүүлэлт, лицензийн төлбөрт 72,850.82 мянган төгрөгийг төлсөн байна. Тухайлбал: e-health программын лицензийн төлбөрт 50,000.0 мянган төгрөг, албан хэрэг хөтлөлтийн программын төлбөрт 14,820.0 мянган төгрөг, сургалтын программын лицензийн төлбөрт 4,800.0 мянган төгрөг, нягтлан бодох бүртгэлийн программын лицензийн төлбөрт 3,230.82 мянган төгрөгийг тус тус төлсөн байна.

Мөн төсөл арга хэмжээ хэрэгжиж дууссан 24,074.7 мянган төгрөг, ашиглалтын хугацаа дуусаж цаашид ашиглах боломжгүй 13,692.7 мянган төгрөгийн Зайн оношилгоо, зайн сургалтын сүлжээний сервер, Интерактив, Макс гэсэн программууд үйл ажиллагаанд ашиглаагаагүй байна.

### **3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### **3.5.1 Төсвийн төлөвлөлт**

Тус байгууллагын 2025 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг эрүүл мэндийн даатгалын сангаас 57,642,486.5 мянган төгрөг, үндсэн үйл ажиллагааны орлогоос 1,183,405.0 мянган төгрөг, туслах үйл ажиллагааны орлогоос 250,000.0 мянган төгрөг, нийт зарлагыг 59,075,891.5 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төслийн саналаас нийт зардлыг 3,678,436.3 мянган төгрөгөөр нэмэгдүүлж эрүүл мэндийн даатгалын сангаас 52,168,045.0 мянган төгрөг, үндсэн үйл ажиллагааны орлогоос 1,950,604.0 мянган төгрөг, туслах үйл ажиллагааны орлогоос 5,780,914.9 мянган төгрөг, урьд оны үлдэгдлээс 2,854,763.9 мянган төгрөг, нийт 62,754,327.8 мянган төгрөгөөр орлогын эх үүсвэрийг баталсан байна

Энэ нь төсвийн төслийг боловсруулахдаа бодит тоо мэдээг үндэслэн судалгаа, тооцоолол хийгээгүй, үндэслэлтэй төлөвлөөгүйгээс шалтгаалсан байна.

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 5 арга хэмжээг санхүүжүүлэхээр 52,168,045.0 мянган төгрөгийг эрүүл мэндийн даатгалын сангаас, 1,950,604.0 мянган төгрөгийг үйл ажиллагааны орлогоос, 5,780,914.9 мянган төгрөгийг туслах үйл ажиллагааны орлогоос, урьд оны үлдэгдлээс 2,854,763.9 мянган төгрөг, нийт 62,754,327.8 мянган төгрөгийн орлого бүрдүүлэхээр байна.

#### **3.5.2 Төсвийн гүйцэтгэл**

Гүйцэтгэлээр Эрүүл мэндийн даатгалын сангаас 52,166,035.8 мянган төгрөгийн санхүүжилт олгож, үйл ажиллагааны орлого 1,330,587.2 туслах үйл ажиллагааны орлого 5,217,375.3 нийт 58,713,998.4 мянган төгрөгийн орлого бүрдүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 60,555,296.2 мянган төгрөг буюу 96.5 хувьтай байгаа нь үндсэн үйл ажиллагааны зардлын төсвийг 589,494.7 мянган төгрөг, ажил олгогчоос олгох тэтгэмж, шагнал урамшууллын зардлыг 64.4 мянган төгрөг, эм бэлдмэл эмнэлгийн хэрэгслийн зардлыг 4,146.8 мянган төгрөг, олон улсын байгууллагаас олгосон нэмэлт санхүүжилтийн зардлыг 99,819.5 мянган төгрөг, дээд шатны төсөв захирагчаас хуваарилсан зардлыг 1,505,506.2 мянган төгрөгөөр тус тус дутуу зарцуулсантай холбоотой байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл /мянган төгрөгөөр/

код	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
<b>71602</b>	<b>Эмнэлгийн тусламж үйлчилгээ</b>	<b>62,754,327.8</b>	<b>60,555,296.2</b>	<b>2,199,031.6</b>	<b>96.5</b>
80101	Үндсэн үйл ажиллагааны зардал	52,307,490.4	51,717,995.7	589,494.7	98.9
80802	Ажил олгогчоос тэтгэмж, шагнал урамшуулал	54,698.7	54,634.3	64.4	99.9
81639	Эм бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	377,166.0	373,019.2	4,146.8	98.9
83601	Нэмэлт- Олон улсын байгууллагаас олгосон	1,663,763.7	1,563,944.2	99,819.5	94.0
83603	Нэмэлт- Дээд шатны төсвөөс хуваарилсан	8,351,209.0	6,845,702.8	1,505,506.2	82.0

**1. Байгууллагуудын орон тооны цомхотголын талаар**

Тайлант онд нийт орон тоог 1267 ажилчидтай байхаар баталж цалингийн санг 32,471,043.9 мянган төгрөгөөр төлөвлөсөн байна. Гүйцэтгэлээр ажил үүргийн давхардлыг арилган, ажлын ачааллыг тооцон удирдах болон гүйцэтгэх албан тушаалын 48 орон тоо, үйлчилгээний ажилчдын норм нормативыг тооцон 38 орон тоог тус тус цомхотгож цалингийн зардлаас 117,894.4 мянган төгрөгийг хэмнэсэн байна.

**2. Унаа, хоолны хөнгөлөлтийн зардлын тарифын талаар:**

Эх хүүхдийн эрүүл мэндийн төвийн даргын 2019 оны А/11 дугаар тушаалаар ажлын нэг өдрийн хоолны зардалыг 4.0 мянган төгрөг, унааны зардалыг 1.0 мянган төгрөгөөр тогтоож тайлант хугацаанд хоолны зардалд 1,113,475.0 мянган төгрөг, унааны зардалд 6,774.4 мянган төгрөг нийт 1,120,249.4 мянган төгрөгийг олгосон байна.

**3. Гадаад томилолт, арга хэмжээний судалгааны үр дүн:**

Гадаад томилолтын зардалд Эрүүл мэндийн хөгжлийн төвийн 252 дугаар гэрээгээр, ЭХЭМҮТ-ийн захирлын А\27 тоот тушаалаар БНХАУ-н Фудан эмнэлэг дээр "Хүүхэд нярайн зүрхний мэс засал"-ын чиглэлээр 6 сарын хугацаатай 8 хүний бүрэлдэхүүнтэй багийг 109,304.3 мянган төгрөгийн сургалтын төлбөр, замын зардал, томилолтын зардалд зарцуулсан байна.

НҮБ-ийн ХАС-ийн санхүүжилтээр зохион байгуулагдсан арга хэмжээний дагуу томилолтын зардалд нийт 15,000.0 мянган төгрөг батлагдаж, гүйцэтгэлээр 14,897.7 мянган төгрөгийн зарцуулсан байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

**3.5.3 Нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т "нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн

бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант онд нэмэлт санхүүжилтийн дансаар орлого, зарлагын ажил гүйлгээ хийгдээгүй байна.

### 3.5.3.1 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Тайлант хугацаанд Нэгдсэн үндэсний байгууллагын хүн амын сангийн тусламжаар 21 төсөлд зориулж 1,329,371.6 мянган төгрөг, дэлхийн эрүүл мэндийн байгууллагын тусламжаар 6 төсөлд зориулж 35,618.0 мянган төгрөг, Прожект Орбис интернэшнл ТББ-ийн тусламжаар 4 төсөлд зориулж 71,941.8 мянган төгрөг, НҮБ-ийн хүүхдийн сангийн тусламжаар 2 төсөлд зориулж 226,832.3 мянган төгрөг, нийт 33 төсөлд 1,663,763.7 мянган төгрөгийн санхүүжилт олгосон бөгөөд 30 төсөл бүрэн хэрэгжиж дууссан 3 төсөл хэрэгжих шатандаа байна.

*/мянган төгрөгөөр/*

д/д	Тусламж үзүүлсэн байгууллагын нэр	Төслийн тоо	Зарцуулах төсөв	Зарцуулсан төсөв	Зөрүү
1	НҮБ-ын Хүн амын сан	21	1,329,371.6	1,250,678.0	78,693.6
2	ДЭМБ	6	35,618.0	34,748.4	869.6
3	ОРБИС	4	71,941.8	68,021.0	3,920.8
4	НҮБ-ын Хүүхдийн Сан	2	226,832.3	210,496.8	16,335.5
	<b>Дүн</b>	<b>33</b>	<b>1,663,763.7</b>	<b>1,563,944.2</b>	<b>99,819.5</b>

Нэгдсэн үндэсний байгууллагын хүн амын сангийн тусламжаар хэрэгжсэн Өсвөр насныхны жирэмслэлт болон үр хөндөлтийн түвшний судалгаа, эх барихын үжлийн эмнэл зүйн менежментийн удирдамжийг боловсруулах төсөл, ДЭМБ-ийн тусламжаар хүүхдийн хорт хавдрын эм нийлүүлэх төслийн тоног төхөөрөмж бараа материал нь бүрэн нийлүүлэгдээгүйгээс 2026 онд шилжүүлэн хэрэгжүүлэхээр хугацааг сунгасан байна.

### 3.5.4 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Тус төв нь 2025 онд 18,490,000.0 мянган төгрөгийн төсөвт өртөгтэй 12 багц бараа, ажил, үйлчилгээг худалдан авахаар төлөвлөсөн байна. Үүнээс нээлттэй тендер сонгон шалгаруулалтын аргаар 18,295,604,7 мянган төгрөг, харьцуулалтын аргаар 194,434.2 мянган төгрөгийн арга хэмжээг сонгон шалгаруулахаар тус тус төлөвлөж, гүйцэтгэлээр 15 багц ажил үйлчилгээнд 17,798,076.6 мянган төгрөгийн худалдан авалтыг хийсэн.

## 4. АУДИТЫН ТАЙЛАН

### 4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Эх, хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төвийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийсэн байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулах, дотоод хяналтыг сайжруулахтай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Гэрэлт хөхийн тэнцвэр аудит ХХК-ийн ахлах аудитор Д.Хишгээ, аудитор Ш.Нарантуяа, туслах ажилтан Ц.Аюушжав нар гүйцэтгэж, анхан шатны хяналтыг ахлах

захирал Д.Баатарсайхан, Санхүүгийн аудитын газрын ахлах аудитор М.Пагамдулам, аудитын менежер В.Эрдэнэцогт, газрын захирал, тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг нар дараагийн шатны хяналтыг тус тус хэрэгжүүлсэн.

Эх, хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төвийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Үндэсний аудитын газарт 2026 оны 01 дүгээр сарын 23-ны өдрийн 62 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

#### **4.2 Материаллаг байдал**

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “дунд” гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2024 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 69,984,862.3 мянган төгрөгөөс 1 хувиар буюу 699,848.6 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

#### **4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт**

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор байгууллагын тэвчиж болох зардлыг хэмнэн нэн тэргүүний шаардлатай бус худалдан авалт хийгээгүй, тогтмол зардал хэмнэх санамж гарган аян өрнүүлэх зэрэг арга хэмжээ авч ажиллаж нормын хувцас зөөлөн эдлэлийн зардлыг 45,256.7 мянган төгрөг, эд хогшил, урсгал засварын зардлыг 136,757.1 мянган төгрөг, багаж техник хэрэгсэл зардлыг 197,636.4 мянган төгрөгөөр тус тус хэмнэсэн байна.

#### **4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

Нийцлийн асуудлаар илэрсэн нийт 3 зөрчлөөс 2 зөрчилд албан шаардлага хүргүүлж, 1 зөрчилд зөвлөмж өглөө.

##### **4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны цахим системд хагас жилийн санхүүгийн тайлан, төсвийн төсөлд өгсөн санал, төсвийн гүйцэтгэл зэрэг нийт 11 мэдээллийг хугацаа хоцроон байршуулсан байна. Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3-т "тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх", 6 дугаар зүйлийн 6.1-д "Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага, албан тушаалтан дараах мэдээллийг тогтмол мэдээлнэ", 6.1.1-д "тухайн жилийн төсөв, худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, орон нутгийн хөгжлийн сангийн төлөвлөлтийг жил бүрийн 01 дүгээр сарын 10-ны өдрийн дотор", 6.1.2-т "хагас жилийн төсвийн гүйцэтгэлийг жил бүрийн 08 дугаар сарын 15-ны өдрийн дотор, өмнөх оны төсвийн гүйцэтгэлийг жил бүрийн 04 дүгээр сарын 25-ны өдрийн дотор, сар, улирлын гүйцэтгэлийг дараа сарын 08-ны өдрийн дотор", 6.1.3-т "дараа жилийн төсвийн төслийг жил бүрийн 09 дүгээр сарын 15-ны өдрийн дотор", 6.1.4-д "жилийн эцсийн санхүүгийн тайланг дараа жилийн 04 дүгээр сарын 25-ны өдрийн дотор, хагас жилийн тайланг 08 дугаар сарын 15-ны өдрийн дотор", 6.1.6-д "төсвийн хэмнэлт, хэтрэлт, түүний шалтгааны тайлбарыг улирал бүр", 6.4.7-д

"байгууллагын батлагдсан орон тоонд орсон өөрчлөлт" гэсэн заалтуудтай тус тус нийцээгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Шилэн дансны хуулийг хэрэгжүүлээгүй, системд мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан, зөрчлийг таслан зогсоох албан шаардлага хүргүүлэх.

#### 4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

1. Гар угаах хэрэгсэл худалдан авах 172,280.0 мянган төгрөгийн төсөвт өртөгтэй худалдан авах ажиллагааны сонгон шалгаруулалтад төсөвт өртгийн 80.0 хувь буюу 121,480.0 мянган төгрөгийн санал ирүүлсэн компанийг шалгаруулсан нь бараа, ажил, үйлчилгээний хамрах хүрээ, чанар болон гүйцэтгэлд сөрөг нөлөө үзүүлэхгүй талаар үндэслэл бүхий тайлбар ирүүлээгүй, тендерийн баримт бичгийн тусгай нөхцөлийн шаардлага хангаагүй байна. Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.5-т "Улсын төсвийн хөрөнгөөр санхүүжүүлэх төсөл, арга хэмжээний тендер шалгаруулалтын оролцогч тендерийн үнийг төсөвт өртгийн 80 хувиас доош үнэ санал болгох бол уг үнэ нь бараа, ажил, үйлчилгээний хамрах хүрээ, чанар болон гүйцэтгэлд сөрөг нөлөө үзүүлэхгүй талаар үндэслэл бүхий тайлбарыг тендерт ирүүлнэ" гэсэн заалттай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Тендерийн баримт бичгийн тусгай нөхцөлийн шалгуур хангаагүй компанийг шалгаруулсан зөрчлийг таслан зогсоож, албан шаардлага хүргүүлэх.

2. ЭХЭМҮТ-ийн Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг 2020 онд бэлтгэсэн бөгөөд түүнээс хойш нэмэлт өөрчлөлт, шинэчлэлт хийгдээгүй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.2-т "Аж ахуйн нэгж, байгууллагын удирдлага нь нягтлан бодох бүртгэлийн хууль тогтоомж, стандарт, дүрэм, журам, зааварт нийцүүлэн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг баталж, мөрдөж ажиллана", 20.2.2-т "аж ахуйн нэгж, байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг боловсруулах, батлуулах, хэрэгжилтийг зохион байгуулах" гэж заасантай тус тус нийцээгүй.

Өгсөн зөвлөмж: Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт төсвөөс нэмэлт зардал гаргахгүйгээр шинэчлэн сайжруулж, мөрдөх.

#### 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

##### 4.5.1 Завсрын аудитын талаар

Завсрын аудитаар шалгагдагч байгууллагын 2025 оны 3 улирлын санхүүгийн тайланг хамруулж, мөнгөн хөрөнгө, бараа материал, үндсэн хөрөнгө, худалдан авах ажиллагааны дансанд горим, сорил хэрэгжүүлж, илэрсэн асуудлыг жилийн эцсийн аудитаар нэгтгэн дүгнэж асуудлын бүртгэлд тусгасан.

##### 4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 1,496,691.9 мянган төгрөгийн 4 албан шаардлага, 611,570.1 мянган төгрөгийн 16 зөвлөмж өгснөөс, 2 зөвлөмжийн хэрэгжилт хангалтгүй, биелэлт 97.8 хувьтай байна.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Албан шаардлага	4	1,496,691.9	4	1,496,691.9	100.0
Зөвлөмж	16	611,570.1	14	611,570.1	95.6
<b>Нийт дүн</b>	<b>20</b>	<b>2,108,262.0</b>	<b>18</b>	<b>2,108,262.0</b>	<b>97.8</b>

Эрүүл мэндийн даатгалын сангаас нэхэмжилсэн санхүүжилтийн хасагдал болон төрийн болон орон нутгийн өмчөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөвлөмжийн хэрэгжилт хангалтгүй зөрчил давтагдсан тул албан шаардлага хүргүүлэхээр шийдвэрлэлээ.

#### 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар Хүүхдийн зөвлөх поликлиник"-ийн өргөтгөлийн 6 давхар барилга, Эх хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төвийн ажилчдын 150 ортой "Хүүхдийн цэцэрлэг"-ийн барилга, 2022, 2024 онд хүчил төгрөгийн үйлдвэр, ЭБЭЭ үйлдвэр-2 гэсэн хөрөнгүүдийн ашиглах жил, ашиглалтын хугацааг оруулаагүй зэрэг асуудлуудыг нарийвчлан авч үзэх шаардлагатай.

### 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 472,009.6 мянган төгрөгийн 3 алдаа<sup>1</sup> илэрснээс аудитын явцад 472,009.6 мянган төгрөгийн 3 алдааг залруулсан.

*Залруулсан алдаа:*

- Цалин, НДШ-ийн зардал 84,489.4 мянган төгрөгийг байгууллага, хувь хүнд өгөх өглөг, бусад өглөгийн дансаар дамжуулан бүртгэж стандартын дагуу бүртгээгүй;
- Үр дүнгийн тайланд тусгасан цалингийн зардал, ажил олгогчоос төлөх НДШ-ийн зардлын дүнг нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн тайлангаас 337,787.1 мянган төгрөгөөр илүү илэрхийлсэн;
- Үр дүнгийн тайланд акталсан бараа материалыг 49,733.01 мянган төгрөгөөр дутуу тайлагнасан;

Энэ нь УСНББОУС-1-ийн 27-д "Санхүүгийн тайланд байгууллагын санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээг үнэн зөв толилуулах ёстой. Үнэн зөв толилуулга нь ажил гүйлгээ, бусад үйл явдал ба нөхцөл байдлуудыг үзэл баримтлалд заасан хөрөнгө, өр төлбөр, орлого, зардлын тодорхойлолт болон хүлээн зөвшөөрөлтийн шалгуурт нийцүүлэн үнэн зөв илэрхийлэхийг шаарддаг" гэсэнтэй нийцээгүй, санхүүгийн тайлагналын тодруулга ба толилуулга батламж мэдэгдлийг хангаагүй.

Аудитаар нийт 2,932,837.0 мянган төгрөгийн зөрчил<sup>2</sup> илэрсэнд, 8,088.7 мянган төгрөгийн 1 төлбөрийн акт тогтоож, 2,523,540.9 мянган төгрөгийн 5 албан шаардлага хүргүүлж, 401,207.3 мянган төгрөгийн 5 зөвлөмж өгсөн.

<sup>1</sup> Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/;

<sup>2</sup> Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

Нийт илрүүлсэн алдаа, зөрчлөөс 2,932,837.0 мянган төгрөгийн залруулагдаагүй алдаа, зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс 2,232,988.4 мянган төгрөгөөр давсан тул “Хязгаарлалттай” дүгнэлт өглөө.

### 5.1 Төлбөрийн акт

1. Аж ахуйн нэгж байгууллагатай байгуулсан түрээсийн гэрээгээр "Наран ивээлт хайрхан" ХХК-аас 2,940.0 мянган төгрөг, "Си Жи Эл баян март" ХХК-аас 1,548.7 мянган төгрөг, "ЭММО" ХХК-аас 3,600.0 мянган төгрөгийн түрээсийн төлбөрийг тус тус дутуу төвлөрүүлсэн байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3-т "Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт", 5 дугаар зүйлийн 5.1.4-т "үнэн зөв байх" хуулийн, 20 дугаар зүйлийн 20.2-д "Ерөнхий нягтлан бодогч дараах үүрэг хүлээнэ", 20.2.4-д "нягтлан бодох бүртгэл хөтлөлт нь энэ хууль болон санхүүгийн бусад хууль тогтоомжид заасан шаардлагад нийцэж байгаа эсэхийг хянах" 20.2.6-т "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах" гэсэн заалтуудтай тус тус нийцээгүй.

Шийдвэрлэсэн нь: Түрээсийн дутуу төвлөрүүлсэн 8,088.7 мянган төгрөгийг буруутай этгээдээр төлүүлэх төлбөрийн акт тогтоов.

### 5.2 Албан шаардлага

1. Сод монгол ХХК-тай байгуулсан шатахуун нийлүүлэх гэрээнд тусгасан нэгжийн үнээс А-92 бензинийг 263.00 төгрөгөөр, дизелийн түлшийг 327.00 төгрөгөөр, дизелийн түлш еврог 382.00 төгрөгөөр тус тус илүү үнээр худалдан авснаас, нийт 4,514.7 мянган төгрөгөөр илүү үнээр бэлтгэсэн, мөн НИК ХХК-тай "шатахууны талоноор газрын тосны бүтээгдэхүүн нийлүүлэх" үнийн дүнгүй гэрээ байгуулж 9,000.0 мянган төгрөгийн шатахууныг худалдан авсан байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-д "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ", 20 дугаар зүйлийн 20.2.5-д "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах," Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 39.2.-т "Худалдан авах гэрээний үнийг гэрээ байгуулах эрх олгосон тухай шийдвэрт заасан үнээр тогтооно", 39.3-т "Худалдан авах гэрээнд дараах нөхцөлийг тусгана", 39.3.1-д "гэрээний үнэ" гэсэн заалтуудтай тус тус нийцээгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Гэрээнд тусгасан нэгжийн үнийг баримтлаагүй болон шатахуун нийлүүлэх гэрээний үнэ өртгийг тодорхой тусгаагүй, зөрчлийг таслан зогсоох албан шаардлага хүргүүлсэн;

2. Эрүүл мэндийн сайдын 2025 оны А/05 дугаар тушаалаар улсын төсвийн хөрөнгө оруулалтаар баригдсан 1,281,028.7 мянган төгрөгийн үнэтэй хүчилтөрөгчийн үйлдвэр болон тоног төхөөрөмжийг орлогод авсан боловч одоог хүртэл ашиглалтад оруулаагүй, хөрөнгийн ашиглалтыг сайжруулах талаар арга хэмжээ аваагүй. Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 21 дүгээр зүйл, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1. "Төсвийн байгууллага нь түүний үйл ажиллагааг үр ашигтай удирдлагаар хангаж, ажлын үр дүнг хариуцах үүрэг бүхий төсвийн шууд захирагчтай байна". 16.5.4-д "төсвийн байгууллагын үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэх", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-т "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах

үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ” гэж заасантай Эрүүл мэндийн сайдын 2025 оны А/05 дугаар тушаалын 3-д “Хуваарилсан эмнэлгийн тоног төхөөрөмжийн хадгалалт, ашиглалтад хяналт тавьж ажиллахыг холбогдох эрүүл мэндийн байгууллагын захирал, дарга нарт үүрэг болгосугай” гэж заасантай тус тус нийцээгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Хүчилтөрөгчийн үйлдвэрийг ашиглалтад оруулах, ашиглалтыг сайжруулах арга хэмжээ аваагүй зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлсэн;

3. Бараа материалын дансанд бүртгэлтэй 17 нэр төрлийн 41,850.5 мянган төгрөгийн он дамжсан эм, боох материалын үлдэгдлээс тайлант хугацаанд зарцуулаагүй, хэрэгцээ шаардлагагүй нөөц үүссэн байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, 16 дугаар зүйлийн 16.5.4-д “төсвийн байгууллагын үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэх”, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 4.1.3-т “үр ашигтай байх”, 4.1.6-д “сахилга баттай байх”, 15 дугаар зүйлийн 15.1.6-д “нөөцлөх шаардлагатай бараа, материалыг үр ашиггүй удаан хадгалах, шаардлагагүйгээр их хэмжээгээр бараа, материал бэлтгэх, нөөцлөх” гэж заасантай тус тус нийцээгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төрийн хэмнэлтийн тухай хуулийн холбогдох заалтыг мөрдөөгүй, тооцоо судалгаагүй, хэрэгцээ шаардлагагүй нөөц үүсгэдэг зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлсэн;

4. Хүүхдийн дүрс оношилгооны чадавхыг бэхжүүлэх сургалтад 52,190.8 мянган төгрөг, Хүүхдийн зүрхний олдмол гажгийг оношлох эмч бэлтгэх, зүрхний хэт авайн оношилгооны чадамж олгох сургалтад 124,926.5 мянган төгрөг, сургуульд суурилсан эрт илрүүлэг, үзлэгийн зүрхний эмгэгийг орон нутагт илрүүлэх багийн ажиллагаа үзлэгийн сургалтад 49,715.0 мянган төгрөгийн урьдчилгааг тус тус олгож зарцуулалтын тайланг заавар, журмын дагуу бэлтгэж тайлагнаагүй. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-т “үнэн зөв байх”, 13 дугаар зүйлийн 13.1-т “Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно” 13.7.“Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно”, 18 дугаар зүйлийн 18.1-д “Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ”, 20.2.3-д “холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах” гэж заасантай тус тус нийцээгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Урьдчилгаа тайланг журмын дагуу бэлтгэж тайлагнаагүй, зөрчлийг таслан зогсоох албан шаардлага хүргүүлсэн;

5. Тус төвийн эрүүл мэндийн даатгал хариуцсан ажилтнуудын баримтын бүрдүүлэлтэд тавих хяналт хангалтгүйгээс Эрүүл мэндийн даатгалын сангаас нэхэмжилсэн гүйцэтгэлийн санхүүжилтээс цахим болон эмчийн хяналтаар 960,114.7 мянган төгрөгийн санхүүжилт хасагдсан, өмнөх аудитаар өгсөн зөвлөмж бүрэн хэрэгжээгүй. Энэ нь Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.1-д “даатгуулагчид үзүүлсэн энэ хуулийн 9 дүгээр зүйлд заасан эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний зардлын төлбөрийг эрүүл мэндийн даатгалын сангаас төлүүлэх”, 13.1.2-т “эрүүл мэндийн даатгалын байгууллагатай гэрээ байгуулж, хэрэгжилтийг хангах”, 13.1.4-т “даатгуулагчид үзүүлсэн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний нэр, төрөл, хэлбэр, тоо хэмжээ, зардал болон бусад мэдээллийг бүртгэх, хадгалах, эрүүл мэндийн даатгалын байгууллагад мэдээлэх”, 13.1-д “эрүүл мэндийн даатгалын сангаас төлүүлэх даатгуулагчийн төлбөрийн тайлан тооцоо, холбогдох баримт бичгийг үнэн зөв, цаг хугацаанд нь гаргаж эрүүл мэндийн даатгалын байгууллагад ирүүлэх”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-д “Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ.”, 20 дугаар зүйлийн 20.2.5-д “дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах,

ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах” гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний баримтын бүрдүүлэлтэд тавих хяналтыг сайжруулах, ЭМДС-ын эмчийн хяналтаар хасагддаг зөрчлийг 30.0 хувь хүртэл бууруулж, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллах албан шаардлага хүргүүлсэн.

### **5.3 Зөвлөмж**

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

#### ***Үндсэн хөрөнгийн данстай холбоотой асуудал***

Илрүүлэлт: Эд хариуцагчийн картад хөрөнгийн хөдөлгөөнийг тухай бүр шинэчилж хөтлөөгүйгээс хөрөнгө солигдох эрсдэлтэй байна. Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 71 дүгээр зүйл. 2/ "бараа, материал, үнэ бүхий зүйлийн орлого, зарлагыг цэгцлэн шалгаж, нэр төрлийн бүртгэлийг эд хариуцагч бүрээр хөтлүүлж тайлан гаргуулан үлдэгдлийн бүртгэлтэй тулган шалгасан байх;" Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3-д "Холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар" гэсэн заалттай нийцээгүй байна.

Өгсөн зөвлөмж: Хөрөнгийг хөдөлгөөнийг эд хариуцагчийн картад тухай бүрд хөтөлж, дотоод хяналтыг сайжруулах;

#### ***Бараа материалын данстай холбоотой асуудал***

Илрүүлэлт: Авто тээврийн хэрэгслийг засвар үйлчилгээнд оруулахад өмч хамгаалах зөвлөлийн дүгнэлт гаргуулаагүй 11,200.0 мянган төгрөгөөр автомашины мотор сольсон. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7. Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно. Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн, 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах" гэж заасантай тус тус нийцээгүй.

Өгсөн зөвлөмж: Авто тээврийн хэрэгсэлд засвар үйлчилгээ хийх бүрд өмч хамгаалах зөвлөлийн дүгнэлтийн үндэслэн хийж, хийгдсэн үйлчилгээг техник ашиглалтын дэвтэрт бүртгэж байх;

#### ***Цалингийн зардлын данстай холбоотой асуудал***

##### Илрүүлэлт:

Нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн тайлангаас цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлого, шууд бус орлогод ногдуулан суутгасан албан татварын тайлан дахь цалингийн зардлын дүн 4,714.6 мянган төгрөгөөр дутуу тайлагнасан нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-т "үнэн зөв байх", 20 дугаар зүйл: 20.2.4-д "нягтлан бодох бүртгэл хөтлөлт нь энэ хууль болон санхүүгийн бусад хууль тогтоомжид заасан шаардлагад нийцэж байгаа эсэхийг хянах" 8 Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн 32 дугаар зүйлийн 32.2.2-т "орон тоо болон цалин хөлсний сан, түүнтэй адилтгах орлогын бүрэлдэхүүнийг үнэн зөв тодорхойлж, нийгмийн даатгалын шимтгэлийг энэ хуулиар тогтоосон хувь хэмжээгээр ногдуулж, сар бүр нийгмийн даатгалын санд төлөх", 32.2.3-т "нийгмийн даатгалын холбогдолтой анхан шатны болон нягтлан бодох бүртгэлийг хөтөлж, нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн тайлан, мэдээг гарган энэ хуулийн 25.1-д заасан хугацаанд нийгмийн даатгалын байгууллагад хүргүүлэх" гэж заасантай тус тус нийцээгүй.

**Өгсөн зөвлөмж:** НДШ-ийн хувь хүний орлогын тайланг үнэн зөв тайлагнаж, илэрсэн алдаа, зөрчлийг арилгаж ажиллах;

### **Урсгал зардлын данстай холбоотой асуудал**

#### **1.1 Илрүүлэлт:**

MRI аппаратыг ажиллуулж байхад техник технологийн аюулгүй ажиллагааны заавар, журмыг мөрдөөгүйгээс тус аппаратад гэмтэл гарсны улмаас төлөвлөөгүй засварын зардалд 380,000.0 мянган төгрөгийг зарцуулсан нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1. "Төсвийн байгууллага нь түүний үйл ажиллагааг үр ашигтай удирдлагаар хангаж, ажлын үр дүнг хариуцах үүрэг бүхий төсвийн шууд захирагчтай байна". Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 67 дугаар зүйлийн 1-т "Төрийн өмчит хуулийн этгээдийн эрх баригч нь өмч хөрөнгийн хадгалалт, хамгаалалтын байдалд өдөр тутам тавих дотоодын хяналтыг зохион байгуулж, түүний үр дүнг төрийн өмнө хариуцна", 2-т "Өмч хөрөнгийн хадгалалт, хамгаалалтад бүртгэлээр тавих хяналт шалгалтыг тухайн хуулийн этгээдийн ерөнхий нягтлан бодогч хариуцна" гэж заасантай тус тус нийцээгүй.

**Өгсөн зөвлөмж:** Эмнэлгийн орчин үеийн техник, тоног төхөөрөмжид ажиллах ажилтанд аюулгүй ажиллагааны заавар журмыг мөрдүүлж, болзошгүй эрсдэлээс сэргийлэхэд анхаарч ажиллах;

### **Үндсэн хөрөнгийн данстай холбоотой асуудал**

#### **2.1 Илрүүлэлт:**

Байгууллагын үндсэн хөрөнгөнд бүртгэлтэй, 5,292.6 мянган төгрөгийн дансны үнэтэй манаачийн байр №1-ийг ТӨБЗГ-ын шийдвэргүйгээр хувийн компани өргөтгөж, 120 м.кв талбайтай цайны газрын барилга барьж, 2008 оноос хойш үйл ажиллагаа явуулж ирсэн байна. Тус цайны газартай сар бүр 12 м.кв-аар тооцож, 480.0 мянган төгрөгийн түрээсийн төлбөр төлөх гэрээ байгуулж, хувийн хэвшилд ашиглуулж байгаа бөгөөд хөрөнгийн эзэмших эрхийг шийдвэрлээгүй нь "Төрийн болон орон нутгийн өмчийн тухай" хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.1-д "Төрийн байгууллага, албан газар, төрийн болон орон нутгийн өмчит төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг, нэгдсэн эмнэлэг нь өөр олгогдсон эд хөрөнгийн талаар дараах үүрэгтэй. 1/ өөрт олгогдсон эд хөрөнгийн бүрэн бүтэн байдлыг хангаж, үйл ажиллагааныхаа зорилгод нийцүүлэн зориулалтын дагуу, эзэмшиж, ашиглах", 14.2.4-д "төрийн өмчит эрдэм шинжилгээний байгууллага, их дээд сургууль дэргэдээ бие даасан гарааны компани байгуулахаас бусад тохиолдолд үндсэн хөрөнгөд хамаарах эх хөрөнгө олж авах, захиалах, данснаас хасаж шилжүүлэх, устгах саналаа төрийн өмчийн бодлого зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгуулагд тавьж, энэ хуулиар тогтоосон журмын дагуу зөвшөөрөл авах" гэж заасантай тус тус нийцээгүй.

**Өгсөн зөвлөмж:** ТӨБЗГ-ын болон эд хөрөнгийн эзэмших эрхийг шийдвэрлүүлэх арга хэмжээ авч ажиллах;

Зөвлөмжийн төрийн аудитын байгууллагад 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

### Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

№	Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
								Залруулсан		Залруулаагүй			
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Цалин, НДШ-ийн зардал 84,489.4 мянган төгрөгийг байгууллага, хувь хүнд өгөх өглөг, бусад өглөгийн дансанд буруу бүртгэсэн	1	84,489.4			1	84,489.4	1	84,489.4				
2	Үр дүнгийн тайланд тусгасан цалингийн зардал, ажил олгогчоос төлөх НДШ-ийн зардлын дүнг нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн тайлангаас 337,787.1 мянган төгрөгөөр илүү тайлагнасан байна.	1	337,787.1			1	337,787.1	1	337,787.1				
3	Бараа материалын тодруулгын тайланд бараа материалыг данс бүртгэлээс хасаж акталсан дүнгээс үр дүнгийн тайланд 49,733.01 мянган төгрөгөөр дутуу тайлагнасан	1	49,733.1			1	49,733.1	1	49,733.1				
	<b>Дүн</b>	<b>3</b>	<b>472,009.6</b>			<b>3</b>	<b>472,009.6</b>	<b>3</b>	<b>472,009.6</b>				

### Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Д/Д	Алдаа, зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
1	Эд хариуцагчийн картад хөрөнгийн хөдөлгөөнийг тухай бүр шинэчилж хөтлөөгүйгээс хөрөнгө солигдох эрсдэлтэй.	1	-					1					

2	Тендер сонгон шалгаруулалтаар Сод монгол ХХК-тай шатахуун нийлүүлэх гэрээ байгуулсан боловч гэрээний нэгжийн үнийг нэмэгдүүлж тендерийн төсөвт өртгөөс 4,514.7 мянган төгрөгөөр илүү үнээр шатахуун худалдан авсан мөн нэмэлтээр НИК ХХК-тай шатахууны талоноор газрын тосны бүтээгдэхүүн нийлүүлэх үнийн дүнгүй шууд худалдан авах гэрээ байгуулж 9,000.0 мянган төгрөгийн шатахууныг худалдан авсан байна.	1	13,714.7			1	13,714.70					
3	Авто тээврийн хэрэгслийг засвар үйлчилгээнд оруулахад өмч хамгаалах зөвлөлийн дүгнэлт гаргуулаагүй 11,200.0 мянган төгрөгөөр автомашины мотор сольсон байна.	1	11,200.0				1	11,200.0				
4	Нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн тайлангаас цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлого, шууд бус орлогод ногдуулан суутгасан албан татварын тайлан дахь цалингийн зардлын дүн 4,714.6 мянган төгрөгөөр дутуу тайлагнасан.	1	4,714.7				1	4,714.7				
5	MRI аппаратыг ажиллуулж байхад техник технологийн аюулгүй ажиллагааны заавар, журмыг мөрдөөгүйгээс тус аппаратад гэмтэл гарсны улмаас төлөвлөөгүй засварын зардалд 380,000.0 мянган төгрөгийг зарцуулсан байна.	1	380,000.0				1	380,000.0				
6	Байгууллагын үндсэн хөрөнгөнд бүртгэлтэй, 5,292.6 мянган төгрөгийн дансны үнэтэй манаачийн байр №1-ийг ТӨБЗГ-ын шийдвэргүйгээр хувийн компани өргөтгөж, ,, төгрөгөөр 120 м.кв талбайтай цайны газрын барилга барьж, 2008 оноос хойш үйл ажиллагаа явуулж ирсэн байна.Тус цайны газартай сар бүр 12 м.кв-аар тооцож, 480.0 мянган төгрөгийн түрээсийн төлбөр төлөх гэрээ байгуулж, хувийн хэвшилд ашиглуулж байгаа бөгөөд хөрөнгийн эзэмших эрхийг шийдвэрлээгүй байна	1	5,292.6				1	5,292.6				

7	Аж ахуйн нэгж байгууллага, хувь хүмүүстэй байгуулсан түрээсийн гэрээнээс "Наран ивээлт хайрхан" ХХК-аас 2,940.0 мянган төгрөг, "Си Жи Эл баян март" ХХК-аас 1,548.7 мянган төгрөг, "ЭММО" ХХК-с 3,600.0 мянган төгрөгийн түрээсийн төлбөрийг тус тус дутуу төвлөрүүлсэн	1	8,088.7	1	8,088.7								
8	НҮБ-ийн Хүүхдийн сангаас санхүүжүүлсэн Хүүхдийн дүрс оношилгооны чадавхыг бэхжүүлэх сургалт 52,190.8, мянга, Хүүхдийн зүрхний олдмол гажгийг оношлох эмч бэлтгэх, зүрхний хэт авайн оношилгооны чадамж олгох сургалт 124,926.5 мянга, Сургуульд суурилсан эрт илрүүлэг, үзлэгийн зүрхний эмгэгийг орон нутагт илрүүлэх багийн ажиллагаа үзлэг 49,715.0 мянган төгрөгийн урьдчилгаа олгоод зарцуулалтын тайланг зохих заавар, журмын дагуу бэлтгэж тайлагнаагүй.	1	226,832.3			1	226,832.3						
9	Эрүүл мэндийн сайдын 2025 оны А/05 дугаар тушаалаар 1,281,028.7 мянган төгрөгийн хүчилтөрөгчийн үйлдвэр, тоног төхөөрөмжийн хамт орлогод авсан боловч одоог хүртэл уг үйлдвэрийг ашиглалтад оруулаагүй байна.	1	1,281,028.7			1	1,281,028.7						
10	ЭМДЕГ-ын чанарын болон төлбөрийн хяналтаар тус төвийн баримтын бүрдүүлэлтэд тавих хяналт хангалтгүйгээс шалтгаалан ЭМДС-аас авах нэхэмжлэлээс эмчийн хяналтаар 960,114.7 мянган төгрөг буюу 0,018 хувийн санхүүжилт хасагдсан байна.	1	960,114.7			1	960,114.7						
11	Бараа материалын дансанд он дамжин үлдэгдэлтэй 17 нэр төрлийн 41,850.5 мянган төгрөгийн эм, боох материалаас тайлант хугацаанд зарцуулаагүй, хэрэгцээ шаардлагагүй нөөц үүссэн байна	1	41,850.5			1	41,850.5						
	<b>Дүн</b>	<b>11</b>	<b>2,932,836.9</b>	<b>1</b>	<b>8,088.7</b>	<b>5</b>	<b>2,523,540.9</b>	<b>5</b>	<b>401,207.3</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Шилэн дансны сайтад тайлант хугацаанд 889 мэдээллийг байршуулсан боловч 11 мэдээлэл хугацаа хоцроож, 1 мэдээлэл мэдээллээгүй	1				1			
<b>Дүн</b>	<b>1</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>1</b>			
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
Тендерийн баримт бичгийн тусгай нөхцөлийн шалгуур хангаагүй компанийг шалгаруулсан.	1				1	-		
ЭХЭМҮТ-ийн Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг 2020 онд бэлтгэсэн бөгөөд түүнээс хойш шинээр гарсан нэмэлт өөрчлөлт, шинэчлэлт хийгдээгүй байна..	1						1	
<b>Дүн</b>	<b>2</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>2</b>	<b>-</b>	<b>1</b>	<b>-</b>
<b>Нийт дүн</b>	<b>3</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>2</b>	<b>-</b>	<b>1</b>	<b>-</b>



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 02 сарын 25 өдөр

Дугаар 527/A0150185

Улаанбаатар хот

САГ -2026/361/НА -СТА -ТШЗ

Зөрчил таслан зогсоох тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Эх хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төвийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Сод монгол ХХК-тай байгуулсан шатахуун нийлүүлэх гэрээнд тусгасан нэгжийн үнээс А-92 бензинийг 263 төгрөгөөр, дизелийн түлшийг 327 төгрөгөөр, дизелийн түлш еврог 382 төгрөгөөр тус тус илүү үнэтэй худалдан авснаас, нийт гэрээний үнээс 4,514,760.00 /дөрвөн сая таван зуун арван дөрвөн мянга долоон зуун жаран/ төгрөгөөр илүү үнэтэй бэлтгэсэн, мөн НИК ХХК-тай "шатахууны талоноор газрын тосны бүтээгдэхүүн нийлүүлэх" үнийн дүнгүй гэрээ байгуулж, 9,000,000.00 /есөн сая/ төгрөгийн шатахууныг тус тус худалдан авсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-д "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ", 20 дугаар зүйлийн 20.2.5-д "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах", Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 39 дугаар зүйлийн 39.2-т "Худалдан авах гэрээний үнийг гэрээ байгуулах эрх олгосон тухай шийдвэрт заасан үнээр тогтооно", 39.3-т "Худалдан авах гэрээнд дараах нөхцөлийг тусгана", 39.3.1-д "гэрээний үнэ" гэсэн заалттай тус тус нийцээгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгаагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1.8-д "Байгуулсан гэрээ, хэлцэл, холбогдох дүрэм, журмыг баримтлаагүй", 4.2.1.9-д "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль тогтоомж зөрчсөн нь энэ журмын 4.2.3-т заасан нөхцөл үүсээгүй бол" гэсэн заалтыг тус тус үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Гэрээнд тусгасан нэгжийн үнийг баримтлаагүй, мөн гэрээнд шатахуун нийлүүлэх мөнгөн дүнг тусгаагүй зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Эх хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төвийн захирлын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч /Ж.Отгонбаатар/, ерөнхий нягтлан бодогч /М.Жавхлан/ нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН  
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  
АУДИТЫН МЕНЕЖЕР  
ГЭРЭЛТ ХӨХИЙН ТЭНЦВЭР АУДИТ ХХК-ИЙН  
ЗАХИРАЛ

Ц.НАРАНЧИМЭГ  
В.ЭРДЭНЭЦОГТ

Д.БААТАРСАЙХАН

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр,  
Утас 51-264230

Z:\Alban Shaardlaga\2026\0125 SAG-100.Docx

1526181109



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 02 сарын 25 өдөр

Дугаар 528/АД150185

Улаанбаатар хот

САГ-2026/361/НА-СТА-ТШЗ

Зөрчил таслан зогсоох тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Эх хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төвийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Гар угаах хэрэгсэл бэлтгэх 172,280,000.00 /нэг зуун далан хоёр сая хоёр зуун наян мянган/ төгрөгийн төсөвт өртөгтэй худалдан авах ажиллагааны сонгон шалгаруулалтад төсөвт өртгийн 80.0 хувь буюу 121,480,000.0 /нэг зуун хорин нэгэн сая дөрвөн зуун наян мянган/ төгрөгийн санал ирүүлсэн компанийг шалгаруулсан нь "бараа, ажил, үйлчилгээний хамрах хүрээ чанар болон гүйцэтгэлд сөрөг нөлөө үзүүлэхгүй талаар үндэслэл бүхий тайлбар ирүүлээгүй, тендерийн баримт бичгийн тусгай нөхцөлийн шаардлага хангаагүй байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.5-т "Улсын төсвийн хөрөнгөөр санхүүжүүлэх төсөл, арга хэмжээний тендер шалгаруулалтын оролцогч тендерийн үнийг төсөвт өртгийн 80 хувиас доош үнэ санал болгох бол уг үнэ нь бараа, ажил, үйлчилгээний хамрах хүрээ, чанар болон гүйцэтгэлд сөрөг нөлөө үзүүлэхгүй талаар үндэслэл бүхий тайлбарыг тендерт ирүүлнэ" гэсэн заалттай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1.9-д "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль тогтоомж зөрчсөн нь энэ журмын 4.2.3-т заасан нөхцөл үүсээгүй бол" гэсэн заалтыг тус тус үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Оролцогчоос тендерийн үнийг төсөвт өртгийн 80 хувиас доош үнэ санал болгох бол уг үнэ нь бараа, ажил, үйлчилгээний хамрах хүрээ, чанар болон гүйцэтгэлд сөрөг нөлөө үзүүлэхгүй талаар үндэслэл бүхий тайлбар аваагүй зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Эх хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төвийн захирлын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч /Ж.Отгонбаатар/, ерөнхий нягтлан бодогч /М.Жавхлан/ нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН  
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  
АУДИТЫН МЕНЕЖЕР  
ГЭРЭЛТ ХӨХИЙН ТЭНЦВЭР АУДИТ ХХК-ИЙН  
ЗАХИРАЛ

Ц.НАРАНЧИМЭГ  
В.ЭРДЭНЭЦОГТ  
Д.БААТАРСАЙХАН



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 02 сарын 25 өдөр

Дугаар 529/А0150185

Улаанбаатар хот

САГ-2026/361/НА-СТА-ТЦУЗ

Зөрчил таслан зогсоох тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Эх хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төвийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Хүүхдийн дүрс оношилгооны чадавхыг бэхжүүлэх сургалтад 52,190,800.00 /тавин хоёр сая нэг зуун ерэн мянга найман зуун/ төгрөг, Хүүхдийн зүрхний олдмол гажгийг оношлох эмч бэлтгэх, зүрхний хэт авайн оношилгооны чадамж олгох сургалтад 124,926,550.0 /нэг зуун хорин дөрвөн сая есөн зуун хорин зургаан мянга таван зуун тавин/ төгрөг, сургуульд суурилсан эрт илрүүлэг, үзлэгийн зүрхний эмгэгийг орон нутагт илрүүлэх багийн ажиллагаа үзлэгийн сургалтад 49,715,000.00 /дөчин есөн сая долоон зуун арван таван мянган/ төгрөгийн урьдчилгааг тус тус олгож зарцуулалтын тайланг заавар, журмын дагуу бэлтгэж тайлагнаагүй.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-т "үнэн зөв байх", 13 дугаар зүйлийн 13.1-т "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно", 13.7."Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно", 18 дугаар зүйлийн 18.1-д "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ", 20.2.3-д "холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах" гэсэн заалттай тус тус нийцээгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1.1-д "нягтлан бодох бүртгэлийг холбогдох стандарт, хууль тогтоомжийн дагуу зохих ёсоор хөтөлж, баталгаажуулаагүй" гэсэн заалтыг тус тус үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Урьдчилгаа тайланг журмын дагуу бэлтгэж тайлагнадаггүй зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2026 оны 12 дугаар сарын 01-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Эх хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төвийн захирлын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч /Ж.Отгонбаатар/, ерөнхий нягтлан бодогч /М.Жавхлан/ нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН  
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  
АУДИТЫН МЕНЕЖЕР  
ГЭРЭЛТ ХӨХИЙН ТЭНЦВЭР АУДИТ ХХК-ИЙН  
ЗАХИРАЛ

Ц.НАРАНЧИМЭГ  
В.ЭРДЭНЭЦОГТ  
Д.БААТАРСАЙХАН

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр,  
Утас 51-264230

Z:\Alban.Shaardlaga\2026\0125 SAG-100.Docx

1526181132



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 02 сарын 25 өдөр

Дугаар 530/А0150185

Улаанбаатар хот

САГ-2026/361/НА - СТА -ТШЗ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Эх хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төвийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Эрүүл мэндийн сайдын 2025 оны А/05 дугаар тушаалаар улсын төсвийн хөрөнгө оруулалтаар баригдсан 1,281,028,691.00 /нэг тэрбум хоёр зуун наян нэгэн сая хорин найман мянга зургаан зуун ерэн нэгэн/ төгрөгийн үнэтэй хүчилтөрөгчийн үйлдвэр болон тоног төхөөрөмжийг орлогод авсан боловч одоог хүртэл ашиглалтад оруулаагүй, хөрөнгийн ашиглалтыг сайжруулах талаар арга хэмжээ аваагүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.4-д "төсвийн байгууллагын үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэх", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-д "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ", Эрүүл мэндийн сайдын 2025 оны А/05 дугаар тушаалын 3-т "Хуваарилсан эмнэлгийн тоног төхөөрөмжийн хадгалалт, ашиглалтад хяналт тавьж ажиллахыг холбогдох эрүүл мэндийн байгууллагын захирал, дарга нарт үүрэг болгосугай" гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1.8-д "байгуулсан гэрээ, хэлцэл, холбогдох дүрэм, журмыг баримтлаагүй" гэсэн заалтыг тус тус үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Хүчил төрөгчийн үйлдвэрийг ашиглалтад оруулах, ашиглалтыг сайжруулах арга хэмжээ аваагүй зөрчлийг арилгаж, биелэлтийг 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Эх хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төвийн захирлын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч /Ж.Отгонбаатар/, ерөнхий нягтлан бодогч /М.Жавхлан/ нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН  
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  
АУДИТЫН МЕНЕЖЕР  
ГЭРЭЛТ ХӨХИЙН ТЭНЦВЭР АУДИТ ХХК-ИЙН  
ЗАХИРАЛ

Ц.НАРАНЧИМЭГ  
В.ЭРДЭНЭЦОГТ

Д.БААТАРСАЙХАН





ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 02 сарын 25 өдөр

Дугаар 531/АД150185

Улаанбаатар хот

САГ-2026/361/КА - СТА - ТУЛЗ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Эх хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төвийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Бараа материалын дансанд бүртгэлтэй 17 нэр төрлийн 41,850,544.19 /дөчин нэгэн сая найман зуун тавин мянга таван зуун дөчин дөрвөн/ төгрөгийн он дамжсан эм, боох материалын үлдэгдлээс тайлант хугацаанд зарцуулаагүй, хэрэгцээ шаардлагагүй нөөц үүссэн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 16 дугаар зүйлийн 16.5.4-д "төсвийн байгууллагын үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэх", Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 4.1.3-т "үр ашигтай байх", 4.1.6-д "сахилга баттай байх", 15 дугаар зүйлийн 15.1.6-д "нөөцлөх шаардлагатай бараа, материалыг үр ашиггүй удаан хадгалах, шаардлагагүйгээр их хэмжээгээр бараа, материал бэлтгэх, нөөцлөх" гэж заасантай тус тус нийцээгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудитормын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1.11-д "хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал" гэсэн заалтыг тус тус үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Төрийн хэмнэлтийн тухай хуулийн холбогдох заалтыг мөрдөөгүй, тооцоо судалгаагүй, хэрэгцээ шаардлагагүй нөөц үүсгэдэг зөрчлийг арилгаж, биелэлтийг 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Эх хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төвийн захирлын албан үргийг түр орлон гүйцэтгэгч /Ж.Отгонбаатар/, ерөнхий нягтлан бодогч /М.Жавхлан/ нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН  
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  
АУДИТЫН МЕНЕЖЕР  
ГЭРЭЛТ ХӨХИЙН ТЭНЦВЭР АУДИТ ХХК-ИЙН  
ЗАХИРАЛ



Ц.НАРАНЧИМЭГ  
В.ЭРДЭНЭЦОГТ  
Д.БААТАРСАЙХАН



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 02 сарын 25 өдөр

Дугаар 532/АД150185

Улаанбаатар хот

САГ-2026/361/НА-СТА-ТШЗ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Эх хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төвийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тус төвийн эрүүл мэндийн даатгал хариуцсан ажилтнуудын баримтын бүрдүүлэлтэд тавих хяналт хангалтгүйгээс Эрүүл мэндийн даатгалын сангаас нэхэмжилсэн гүйцэтгэлийн санхүүжилтээс цахим болон эмчийн хяналтаар 960,114,670.00 /есөн зуун жаран сая нэг зуун арван дөрвөн мянга зургаан зуун далан/ төгрөгийн санхүүжилт хасагдсан, өмнөх аудитаар өгсөн зөвлөмж бүрэн хэрэгжээгүй.

Энэ нь Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.1-д "даатгуулагчид үзүүлсэн энэ хуулийн 9 дүгээр зүйлд заасан эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний зардлын төлбөрийг эрүүл мэндийн даатгалын сангаас төлүүлэх", 13.1.2-т "эрүүл мэндийн даатгалын байгууллагатай гэрээ байгуулж, хэрэгжилтийг хангах", 13.1.4-т "даатгуулагчид үзүүлсэн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний нэр, төрөл, хэлбэр, тоо хэмжээ, зардал болон бусад мэдээллийг бүртгэх, хадгалах, эрүүл мэндийн даатгалын байгууллагад мэдээлэх", 13.1-д "эрүүл мэндийн даатгалын сангаас төлүүлэх даатгуулагчийн төлбөрийн тайлан тооцоо, холбогдох баримт бичгийг үнэн зөв, цаг хугацаанд нь гаргаж эрүүл мэндийн даатгалын байгууллагад ирүүлэх", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-д "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ", 20 дугаар зүйлийн 20.2.5-д "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгаагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.8 "байгуулсан гэрээ, хэлцэл, холбогдох дүрэм журмыг баримтлаагүй", 4.2.1.10-д "аудитаар илэрсэн алдаа, зөрчил, түүнийг арилгахаар өгсөн зөвлөмжийг хугацаанд нь хэрэгжүүлээгүй бол" гэсэн заалтыг тус тус үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний анхан шатны баримтын бүрдүүлэлтэд тавих дотоод хяналтыг сайжруулаагүй, өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлээгүй зөрчлийг арилгаж, биелэлтийг 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг 30 хувь хүртэл бууруулж, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Эх хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төвийн захирлын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч /Ж.Отгонбаатар/, ерөнхий нягтлан бодогч /М.Жавхлан/ нарт даалгав.

**АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:**

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН  
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  
АУДИТЫН МЕНЕЖЕР  
ГЭРЭЛТ ХӨХИЙН ТЭНЦВЭР АУДИТ ХХК-ИЙН  
ЗАХИРАЛ

Ц.НАРАНЧИМЭГ  
В.ЭРДЭНЭЦОГТ

Д.БААТАРСАЙХАН

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр,  
Утас 51-264230

9006109  
ATA14027  
9025051411

Z:\Alban Shaardlaga\2026\0125 SAG-100.Docx



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 02 сарын 25 өдөр

Дугаар 533/А05085

Улаанбаатар хот

САТ-2026/361/НА-СТА-ТМЗ

Зөрчлийг таслан зогсоох тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Эх хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төвийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Шилэн дансны цахим системд хагас жилийн санхүүгийн тайлан, төсвийн төсөлд өгсөн санал, төсвийн гүйцэтгэл зэрэг нийт 11 мэдээллийг хугацаа хоцроон байршуулсан байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3-т "тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх", 6 дугаар зүйлийн 6.1-д "Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага, албан тушаалтан дараах мэдээллийг тогтмол мэдээлнэ", 6.1.1-д "тухайн жилийн төсөв, худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, орон нутгийн хөгжлийн сангийн төлөвлөлтийг жил бүрийн 01 дүгээр сарын 10-ны өдрийн дотор", 6.1.2-т "хагас жилийн төсвийн гүйцэтгэлийг жил бүрийн 08 дугаар сарын 15-ны өдрийн дотор, өмнөх оны төсвийн гүйцэтгэлийг жил бүрийн 04 дүгээр сарын 25-ны өдрийн дотор, сар, улирлын гүйцэтгэлийг дараа сарын 08-ны өдрийн дотор", 6.1.3-т "дараа жилийн төсвийн төслийг жил бүрийн 09 дүгээр сарын 15-ны өдрийн дотор", 6.1.4-д "жилийн эцсийн санхүүгийн тайланг дараа жилийн 04 дүгээр сарын 25-ны өдрийн дотор, хагас жилийн тайланг 08 дугаар сарын 15-ны өдрийн дотор", 6.1.6-д "төсвийн хэмнэлт, хэтрэлт, түүний шалтгааны тайлбарыг улирал бүр", 6.4.7-д "байгууллагын батлагдсан орон тоонд орсон өөрчлөлт" гэсэн заалтуудтай тус тус нийцээгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1.11-д "хууль, тогтоомж, гэрээ хэлцэл зөрчсөн, алдаа зөрчлийг таслан зогсоож давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал үүссэн" гэсэн заалтыг тус тус үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Шилэн дансны хуулийг хэрэгжүүлээгүй, системд мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Эх хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төвийн захирлын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч /Ж.Отгонбаатар/, ерөнхий нягтлан бодогч /М.Жавхлан/ нарт даалгав.орлон гүйцэтгэгч /Ж.Отгонбаатар/, ерөнхий нягтлан бодогч /М.Жавхлан/ нарт даалгав.

**АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:**

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН  
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  
АУДИТЫН МЕНЕЖЕР  
ГЭРЭЛТ ХӨХИЙН ТЭНЦВЭР АУДИТ ХХК-ИЙН  
ЗАХИРАЛ

Ц.НАРАНЧИМЭГ  
В.ЭРДЭНЭЦОГТ  
Д.БААТАРСАЙХАН

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр,  
Утас 51-264230

АТА13067  
9025931411

Z:\Alban Shaardlaga\2026\0125 SAG-100.Docx



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
АКТ

2026 оны 02 сарын 25 өдөр

Дугаар 112/АД150185

Улаанбаатар хот

САГ-2026/361/НА -СТА-ТЦЗ

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Эх хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төвийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Аж ахуйн нэгж байгууллагатай байгуулсан түрээсийн гэрээгээр "Наран ивээлт хайрхан" ХХК-аас 2,940,000.00 *Ихөөр сая есөн зуун дөчин мянган* төгрөг, "Си Жи Эл баян март" ХХК-аас 1,548,750.00 *Инэг сая таван зуун дөчин найман мянга долоон зуун тавин* төгрөг, "ЭММО" ХХК-аас 3,600,000.00 *Гурван сая зургаан зуун мянган* төгрөг нийт 8,088,750.00 *Найман сая наян найман мянга долоон зуун тавин* төгрөгийн түрээсийн төлбөрийг дутуу төвлөрүүлсэн байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3-т "Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт", 5 дугаар зүйлийн 5.1.4-т "үнэн зөв байх", 20 дугаар зүйлийн 20.2-д "Ерөнхий нягтлан бодогч дараах үүрэг хүлээнэ", 20.2.4-д "нягтлан бодох бүртгэл хөтлөлт нь энэ хууль болон санхүүгийн бусад хууль тогтоомжид заасан шаардлагад нийцэж байгаа эсэхийг хянах", 20.2.6-т "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах" гэсэн заалтыг тус тус зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т "Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.3.2-т "төрийн болон орон нутгийн өмчийн эд хөрөнгийг түрээслүүлсэн, ашиглуулсны төлбөр болон борлуулсны орлогыг дутуу төвлөрүүлсэн, эсхүл төвлөрүүлээгүй" гэсэн заалтыг тус тус үндэслэн **ТОГТООХ нь**:

1. Түрээслэгч Наран ивээлт хайрхан" ХХК-аас 2,940,000.00 *Ихөөр сая есөн зуун дөчин мянган* төгрөг, "Си Жи Эл баян март" ХХК-аас 1,548,750.00 *Инэг сая таван зуун дөчин найман мянга долоон зуун тавин* төгрөг, "ЭММО" ХХК-аас 3,600,000.00 *Гурван сая зургаан зуун мянган* төгрөгийн түрээсийн төлбөрийг тус тус нөхөн төлүүлж Үндэсний аудитын газрын Төрийн сан дахь Аудитын шалгалтын орлогын 100900000601 тоот дансанд төвлөрүүлэх;

2. Актын биелэлтийг 2026 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Эх хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төвийн захирлын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч /Ж.Отгонбаатар/, ерөнхий нягтлан бодогч /М.Жавхлан/ нарт хариуцуулав.

**ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН:**

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН  
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  
АУДИТЫН МЕНЕЖЕР  
ГЭРЭЛТ ХӨХИЙН ТЭНЦВЭР АУДИТ  
ХХК-ИЙН ЗАХИРАЛ



Ц.НАРАНЧИМЭГ  
В.ЭРДЭНЭЦОГТ

Д.БААТАРСАЙХАН